



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс 2025 онд
санхүүжүүлэх зарцуулалтын төлөвлөгөөнд
тодотгол хийх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.7.27 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 61 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан Бизнес төлөвлөгөөний Татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс 2025 онд санхүүжүүлэх зарцуулалтын төлөвлөгөөний Нэг. Арилжааны системийн сайжруулалт хэсгийн 1-д "Арилжаа, хяналтын системийн программ хангамжийн шинэчлэл"-ийн 1,585,391,500 (нэг тэрбум таван зуун наян таван сая гурван зуун ерэн нэгэн мянга таван зуу) төгрөг, 2-д "Design study"-ийн 339,608,500 (гурван зуун гучин есөн сая зургаан зуун найман мянга таван зуу) төгрөг, нийт 1,925,000,000 (нэг тэрбум есөн зуун хорин таван сая) төгрөгийг 2,500,000,000 (Хоёр тэрбум таван зуун сая) төгрөг гэж, 575,000,000 (таван зуун далан таван сая) төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосугай.
2. Системийн шинэчлэлтийн ажлыг хугацаанд нь хэрэгжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Дөлгөөн)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1525010100